



НИЙГМИЙН ХҮМҮН БҮТЭЦ ДЭХ ХӨӨРСӨН ТҮМЭН

Б.Даш-Ёндон¹

¹ ШУА-ийн Философийн хүрээлэн, Монгол улс
Цахим шуудан: dashyondon@ipsl.mas.ac.mn

Abstract: The article attempts to divide into icons of social human realities and ideal as an abstractive humane structure classified by shapes and regards to explaining the concept that people are lifted within this image. Concerning of author's reason excited that "demonstrations was conjuncture as individual for "I" consciousness has dissolved, and appealed that elimination of the laws, ethics were effected to roaming people in the appealed to the commission of the offenses.

Keywords: exciting people, people, crowded people, roaming people, onlookers and listeners, voting people, demonstrators

Нийгмийн хүмүн бүтэц хийгээд хөөрсөн түмний асуудал бол нийгмийн философи, социологи, эрх зүйн онол, практикт нэн чухал ач холбогдолтой сэдэв юм. Бид энэ асуудлыг авч үзэхийн тулд эхлээд нийгэм гэж юу вэ? гэдэг талаар нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй. Яагаад гэвэл, бидний энд хөндөж буй асуудал бол нийгмийг танин мэдэхүйн хүрээнд багтдаг нэг судлагдахуун нь юм. Нийгэм гэдэг наад зах нь хоёр утгатай.

1. Хүн төрөлхтнийг хамтын амьдралынх нь тодрхой хэсгүүдэд, өөрөөр хэлбэл, улс орон болгож хувааснаас гарах утга. Ингэвэл, улс орон бүхэн нэг тодорхой нийгэм юм. Нийгэм гэдэг маань төр улсаас гадуур байж болохгүй. Иймд "монголын нийгэм", "оросын нийгэм" гэх мэтээр ярьдаг.

2. Байгалиас хүнийг, байгалийн үзэгдлээс хүмүүсийн амьдралын үзэгдлийг ялган судлах зорилгоос гарсан утга. Нийгэм бол байгалийн бүтээгдэхүүн, тэгсэн атлаа байгалиас харьцангуй бие даасан бүрэлдэл юм.

Ингээд ирэхлээр, нийгмийн асуудал бол, аль ч утгаараа эцсийн дүндээ хүний асуудал юм. Нийгэм бол хүний нийгэм, хүн бол нийгмийн хүн. Энэ бодит байдлаас үүдүүлэн нийгмийн хүмүн бүтцийг

сонирхож үзэх хэрэгтэй болж байна. Тэгвэл, нийгмийн хүмүн бүтэц ямаршүү төрх байдалтай байдаг вэ?

Бидний бодоход, энэ бүтцийг шинжлэх ухааны үүднээс хоёр хувааж болмоор. Тухайлбал:

а. Нийгмийн бодит хүмүн бүтэц

б. Нийгмийн хийсвэр хүмүн бүтэц гэж.

Нийгмийн бодит хүмүн бүтцийн үндэс нь ард түмэн юм. Ард түмнийг бид судалгаандаа бодитой гэж үзэхээс өөр аргагүй. Эл ард түмэн гэдэг ойлголтыг дотор нь үндэстэн, угсаатан, анги давхраа, хувь хүн хэмээн судалж болдог. Хувь хүн бол нийгмийн бодит хүмүн бүтцийн хамгийн жижиг хэсэг нь. Хувь хүн нийгмийн харилцаанд оролцохлоороо Би болдог. Тодруулбал, хувь хүн нийгмийн амьдралд Би гэдгээрээ оролцдог. Энд хувь хүний Би бодитойгоор байж байдаг, бодитойгоор амьдардаг, үйлддэг. Энэ Би нь хөөрсөн түмний дунд орохлоороо өөрийгөө алддаг. Үүнийг хойно жич авч ярина.

Ард түмэн. Энэ бол нийгмийн бодит хүмүн бүтэц дэх хийсвэр, тэхдээ хамгийн бодитой хэлбэр. Хийсвэр гэдгийн учир гэвэл, бусад хэлбэр бүтэцтэйгээ мөн л адилаар ямар нэгэн жишээн дээр энэ бол ард түмэн (за энэ чинь өнөөх ард түмэн)

гээд заагаад хэлчихэж болдоггүй. Хамгийн бодитой гэдгийн учир гэвэл, ард түмэн түүхийг бүтээж байдаг, тодруулбал, улс орны түүхийг хэн бүтээдэг вэ гэвэл, ард түмэн бүтээдэг. Улс орны түүхийг бөөн түмэн бүтээдэггүй.

К.Марксын, ард түмэн бол түүхийг бүтээгч мөн гэсэн үндэслэлийг няцаах аргагүй. К.Марксын санааг баяжуулж Карл Ясперс, ард түмэн бүтэцтэй (үндэстэн, угсаатан, анги, давхраа), амьдралынхаа тогтоц, сэтгэхүй, уламжлалаараа өөрийгөө ухамсарлаж байдаг гэж бичжээ. Нэг улс орны нийт иргэд, ард түмний хувь энэ ухамсрыг үндэсний ухамсар гэнэ. Түүхийн ухамсрыг эзэмшигч нь ард түмэн мөн. Эх хэлээ хадгалан хөгжүүлэгч нь ард түмэн. Нийгэмд бүх юмыг бүтээж байгаа хүмүүс бол ард түмэн. Ард түмэн эрх ашгаа мэддэг, үндэс угсаагаа хамгаалдаг. Эдийн засгаа барьж байгуулж, эрдэм соёлоо хөгжүүлдэг. Төрөө төвхнүүлдэг. Ард түмэн задарч сарниж үгүй болдоггүй. Хийсвэр хүмүн бүтцийн хэлбэрүүдэд ийм шинж байхгүй. Ард түмэн эрх ашгаа мэддэг, үндэс угсаагаа хамгаалдаг. Эдийн засгаа барьж байгуулж, эрдэм соёлоо хөгжүүлдэг. Төрөө төвхнүүлдэг. Ард түмэн задарч сарниж үгүй болдоггүй. Хийсвэр хүмүн бүтцийн хэлбэрүүдэд ийм шинжүүд байхгүй.

Ард түмэн чин шударгаар засаглалаа тогтоохыг демократия гэнэ. Demos (грекээр) ард түмэн, kratos-засаглал гэсэн үг гэдгийг бүгд мэднэ. Дарангуйлагч биш, бөөн түмэн биш, хөөрсөн түмэн биш, чухам ард түмэн л улс орон, нийгэмд хэрэгтэй шударга засаглалыг тогтоох хувь зохиолтой, үүрэгтэй.

Манай Үндсэн хуулинд: «Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна» гэж томъёолсон нь уг нь оносон заалт болой. Гагцхүү, ард түмэн энэ засаглалаа зөв тогтоох ёстой. Засаглалын хэлбэр ард түмний хэрэгцээнд таарч, сонирхолд нийцэж байвал зохионо. Ард түмэн сонгогч түмэн болж хувирах үедээ ухаалаг байж эл шаардлагыг хэрэгжүүлэх учиртай

Демократийг охлократи (ochlos-ын буюу хөөрсөн түмний засаглал) болгох ёсгүй.

Нийгмийн бодит хүмүн бүтэц улмаар өөр талаасаа илэрч болно. Үүнийг нь бид нийгмийн хийсвэр хүмүн бүтэц гэдэг нэр томъёогоор илэрхийлж байна. Эл хийсвэр хүмүн бүтцийн үндэс нь бөөн түмэн юм. Ард түмэн гэдэг ойлголтын шинж чанарууд бөөн түмэнд байдаггүй, тэгсэн атлаа энэ бол нийгмийн философи, хууль зүйн онол, практикт заавал судлагдах ёстой асуудал мөн гэж бодож байна.

Бөөн түмэн. Бөөн түмэнд уламжлал, заншил, өөрийн соёл гэж үгүй, яагаад гэвэл түүнийг үүсгэн гаргадаг жам ёсны үндэс, суурь гэж байхгүй. Бөөн түмэн тогтворгүй, юу гэвэл, гэнэт үүсэж, хурдан сарнидаг. Үүгээрээ ард түмнээс ялгаатай.

Бөөн түмэн гэж юу вэ? гэдгийг түүний бүтцээс харж болно. Зорилгоосоо болж үйлдэлд автаж орон зай, цаг хугацааны хувьд, хаа нэгтээ, хэзээ нэгэн үед хүмүүс цугларан бөөгнөрдөг энэ үзэгдлийн бүтэц олон янз ажгуу. Тэр бүтцийг нь хөлхөлдөгч түмэн; үзэгч түмэн сонсогч түмэн; жагсаал цуглаанд оролцогч; сонгогч түмэн; хөөрсөн түмэн гэх зэргээр ангилж болно. Жишээ нь:

Хөлхөлдөгч түмэн гэдэг нь ажилдаа очих гэж, эсхүл ажлаа тараад бөөн бөөнөөрөө алхагсад, галт тэрэгний, онгоцны, автобусны буудал, зах дэлгүүрээр олноороо хөлхөлдөгчдийг хэлж буй хэрэг. Хөлхөлдөгчдийн баримтлах зан заншил, барьж дагах ёс суртахууны уламжлал гэж тусдаа байхгүй; дээр нь нэмж хэлэхэд, хөлхөлдөгч түмэн зохих хугацаандаа үүсээд, зохих цагтаа сарнин арилдаг.

Үзэгч, сонсогч түмэн. Энэ нь хоёр хуваагдана: а) нэг дор, тодорхой хүрээ хязгаартай зай талбайд хуран цугларсан бөөн түмэн: Тухайлбал, театр, цэнгэлдэх хүрээлэн, биений тамирын заал, соёлын ордонд дуу жүжиг, бөх, хөл бөмбөг, олон нийтийн бусад арга хэмжээг сонирхохоор цугларагсад.

б) тархан байршсан, тэгсэн атлаа цаанаа



олон нийт бологсод. Тухайлбал, орон гэртээ сууж телевиз үзэж, радио сонсогчид, сонин сэтгүүл уншигчид гэх мэт. Эдгээр нь мөн л бөөн түмний шинж чанартай байдаг.

Сонгогч түмэн. Энэ бол бөөн түмний хамгийн хариуцлагатай хэлбэр юм. Яагаад гэвэл, сонгогч түмэн бол ард түмэн гэдэг нэрийнхээ өмнөөс шаг шатны төрийн эрх баригчдыг олж гаргах үүрэгтэй. Энэ бол сонгуулийн насанд хүрсэн иргэд юм. Сонгогч түмэн нь хөөрсөн түмэн, хөлхөлдөгч түмэн, үзэгч, сонсогч түмнээс өөр ойлголт, яагаад гэвэл, тодорхой заагдсан хариуцлагатай (биднийг удирдах этгээдүүдээ сонгох хариуцлага), эрхлэн шийдвэрлэх ёстой асуудал бүхий субъект юм. Энэ бол ард түмнийг төлөөлөх бөөн түмэн юм. Сонгогч түмэн тухайн цагтаа үүргээ гүйцэтгээд сарнидгаараа бөөн түмний (үйлдлийн) нэг илрэл болдог. Юу гэвэл, сонгууль болоход сонгогч түмэн үүсдэг, сонгууль дуусахаар энэ түмэн санал өгөгч гэдэг ойлголтын хувьд яригдахаа больдог байна.

Жагсаал цуглаанд оролцогсод. Энэ ч бидэнд үндсэндээ тодорхой. Гэхдээ үүнийг наад зах нь 3 ангилж болно:

а. Баяр ёслолын (энэ нь ил зохион байгуулалттай) утга чанартай жагсаал, цуглаан;

б. Саналбодлоолоннийтилэрхийлэхээр хаа нэгэн талбарт бөөгнөрсөн цуглаан;

в. Эсэргүүцлийн утга чанартай жагсаал, цуглаан. Энэ далд удирдлагатай, зохион байгуулалтгүй мэт харагддаг. Уг нь бо ямар ч цуглаан сэдэгчгүйгээр, удирдагчгүйгээр үүсдэггүй.

Юутай ч гэсэн чухам энэ л хөөрсөн түмэн үүсэх эх үндэс болдог байна. Иймд хөөрсөн түмнийг бид хүсүүшгүй талаас нь үзэж судлах хэрэгтэй.

Хөөрсөн түмэн. Энэ бол нийгмийн хийсвэр хүмүн бүтэц дотроос сугалан авч судлууштай, эрх баригчид агаад хууль сахиулагчид маш анхааруштай нийгмийн үзэгдэл юм. Хөөрсөн түмэн нь бөөн түмний дээр дурдсан бүтэц бүрээс

аяндаа гарч ирдэггүй, чухамдаа эсэргүүцэн цугларагсдаас, тодруулбал эсэргүүцлийн цуглаан, жагсаалаас гардаг байна. Хөөрсөн түмний гэмт үйлдлийн сэтгэл зүй энэ жагсаал цуглааны сэтгэл зүй дотор зүүрмэглэн суудаг. Энэ нь Аристотелийн хэлсэн: «Үнэнч хайрын сэтгэл дотор үзэн ядахуй зүүрмэглэн суудаг» гэдэгтэй агаар нэг амой. Ер нь, юмны диалектик ийм. Ухаандаа, амь дотор үхэл зүүрмэглэж суудаг, эрүүл дотор өвчин зүүрмэглэж суудаг гэх мэт. Тэхдээ энэ нь хайр үзэн ядахуй хоёр, амь үхэл хоёр, эрүүл өвчин хоёр хос хосдоо адил гэсэн үг биш. Үүнчлэн эсэргүүцлийн жагсаал цуглаанд оролцогсод, хөөрсөн түмэн хоёр адилгүй. Үнэнч хайр урвасан бол үзэн ядахуй гарч ирнэ, амь төгсөж байгаа үхэл гарна, эрүүл мэнд эвдрэхэд өвчин ирнэ. Үүнчлэн эсэргүүцлийн жагсаал, цуглааны зохион байгуулалт алдагдахад хөөрсөн түмэн үүснэ.

Зохион байгуулалт нь алдагдах нөхцлүүд гэвэл:

- Эсэргүүцлийн жагсаал цуглаанд гаднаас хүч хэрэглэх гэж оролдох;
- Зохион байгуулалт алдагдвал аюултай гэдгийг ийм жагсаал цуглаанд оролцогчдын дотроос ч, түүнийг санаачлан удирдагчдын зүгээс ч, хууль сахиулагчдын талаас ч сайтар анхааруулахгүй орхивол;
- Эсэргүүцлийн жагсаал цуглаанд оролцогчдын дундаас зориуд өдөөн хатгавал;
- Ийм жагсаал цуглаанд оролцогчид эхнээсээ гэмт хэргийн санаатай байсан бол гэх зэрэг амой.

Тэгвэл хөөрсөн түмэн гэж юу вэ? Юуны өмнө тэмдэглэхэд, 100 гаруй жилийн өмнө (1890 оны эхээр) итали хэлээр хэвлэгдсэн «Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг» гэдэг зохиолдоо Сципион Сигеле энэ асуудлыг нилээд тодорхой, өргөн далайцтай судалсан байна. Энэ зохиолыг миний бие оросоос орчуулж 2002 онд хэвлүүлсэн билээ. Үүнтэйгээ холбогдуулж нэг зүйлийг зориуд тэмдэглэн хэлье. Юу гэвэл, 2008 оны 7-р сарын 1-нд Монголд

болсон үйл явдлыг зарим хүн энэ номтой холбосон яриа гаргасныг санаж байна. Ер нь бид юмыг углуургаас нь, эерэг талаас нь бодож үзэж сурах хэрэгтэй. Энэ их чухал. Хэрэв хэн нэгэн нь «Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг» гэдэг номыг орчуулан хэвлүүлсэн бол энэ нь хөөрсөн түмнийг ингэж үүсгэ, тэр хөөрсөн түмэн нь ингэж-тэгж гэмт хэрэг үйлд гэж зөвлөх гэсэн хэрэг огтхон ч биш билээ. Харин хөөрсөн түмэн үүсэх бололцоотой, түүний үүсэх бололцоо нөхцөл нь ийм-тийм байдаг, тэр нөхцлийг нь бүрдүүлэхгүй байх нь чухал, хөөрсөн түмэн үүсвэл тийм-ийм гэмт хэргийг тэгж-ингэж үйлдэж чадна, үүнээс сэргийлэх хэрэгтэй гэдгийг л ойлгуулах гэсэн хэрэг. Зорилго нь энэ байв.

С.Сигеле энэ зохиолдоо хөөрсөн түмэн гэдгийг тодорхойлж:

«...социологийн хуулинд захирагддаггүй, харин хамт нийтийн сэтгэл зүйн хуулинд бүрнээ захирагддаг элдэв маягийн түр зуурын цугларалтыг хөөрсөн түмэн гэж нэрлэж болно» (29-р тал) гэжээ. Зуу гаруй жилийн өмнө томъёлогдсон гэхэд энэ тодорхойлолт маш сайн болсон юм шиг санагддаг. Тэхдээ энд «элдэв маягийн түр зуурын цугларалтыг хөөрсөн түмэн гэж нэрлэж болно» гэсэн нь одоогийн байдал нөхцлөөс харвал дэндүү өргөн, ерөнхий утгатай болсон нь ойлгомжтой, түүний хамт эл тодорхойлолт С.Сигеле тус номондоо хөөрсөн түмний тухай маш нарийвчлан шинжилж хийсэн өөрийнх нь дүгнэлт санааг бүрэн хамж чадаагүй юм шиг санагдаж байна. Тодруулбал, өдгөөгийн нөхцөлд ч гэсэн хөөрсөн түмэн гэдгийг түүний үйлддэг чухамхүү гэмт хэрэг лүгээ нь холбон үзэх хэрэгтэй. Ингэвэл, бид, жагсаал цуглаанд нийлж бүрэлдэхдээ хувь хүний Би-ийн ухамсрыг уусган арилгаж хууль ёс, ёс суртахууныг давж гэмт хэрэг үйлдэх рүү орсон бөөн түмний хэлбэрийг хөөрсөн түмэн хэмээн нэрлэж болно. Өнөөдөр би хөөрсөн түмэн гэдгээр үүнийг л тэмдэглэн хэлж байна.

Хөөрсөн түмэн газар дээрээ ямар

байдалтай байдаг вэ?. Үүнийг С.Сигелийн дурдсан номонд орсон бусад судлаачдаас авсан ишлэл, түүний өөрийнх нь хэлсэн санаа зэргийг товчхон толилуулах аргаар харуулъя.

Г.Тард “хөөрсөн түмэн гэдэг бол хоорондоо танил бус, ялгаа заагтай этгээдүүдийн овоолго мөн. Тэчъяадлын оч нэгээс нөгөө рүү нь үсрэн шилжиж, энэхүү эмх цэгцгүй бөөн түмнийг (масса) цахилгаанжуулахад л эл бөөн түмэн ямар нэгэн гэнэтийн мэт, аяндаа буй болсон зохион байгуулалтанд орчихдог. Тархай бутархай байдал хэлхээ холбоонд шилжиж орилоон шуугиан нь зорилгодоо хүрэх гэж тогтоон барихын аргагүйгээр тэмүүлсэн ямар нэгэн аймшигт урсгал болон хувирдаг. Уг нь эдний олонхи нь зүгээр л сонинчирхан энд ирсэн билээ; гэтэл хэдхэн этгээдийг хамарсан долгилол хүн бүхний зүрхийг гэнэтэд хөндөн, бүгдээрээ нийлэн устган сүйтгэхээр зүтгэдэг. Буруугүй хүнийг алуулахаас хамгаалах гэж гүйж ирсэн хүн ч хэн нэгнийг алах гэсэн эрмэлзлэлээр хамгийн түрүүнд цэнэглэгдэгчийн нэг болчихдог юм, тэгээд хамгийн хачирхалтай нь тэрээр үүндээ огт гайхдагтүйд оршино” (35-36-р тал) гэж бичжээ.

Энд хөөрсөн түмний гол шинжийг үндсэнд нь бүрэн гаргажээ. Тухайлбал, хөөрсөн түмэн бол хоорондоо танил бус хүмүүс, эмх цэгцгүй бөөн түмэн мөн, энэ нь тархай бутархай байснаа гэнэт зохион байгуулалтад ордог, үүний уршгаар ямар нэгэн аймшигт урсгал болон хувирдаг, ингэхэд нь тэчъяадлын оч нэгээс нөгөө рүү шилжих нь нөлөөлдөг, энд орилоон шуугиан ноёрхдог, уг нь энд олонхи нь зүгээр сонирхогчид байдаг; гэвч тэд нь хэдхэн этгээдийн долгилолд автаж тэдэнтэй хамсан устгах, сүйтгэхээр зүтгэдэг, хөөрсөн түмний гэмт хэргээс сэргийлэхээр гүйж ирсэн хүн ч тэдний цэнэгэнд автчихдаг байна.

Судалгааны дүнгээ үндэслэж С.Сигелийн хэлж буйгаар энд “зүрх сэтгэл сайтай хүмүүстэй харгис хэрцгий,



дүлий дүмбэ хүмүүс, үнэнч шударга хүмүүстэй тэнүүлчид, гэмт хэрэгтнүүд зэргэцэн байдаг” (63-р тал) ажээ. Энд сайн сэтгэлтнүүд нь сайн нөлөө үзүүлэх гэсэн ч чаддаггүй-боломжгүй, яагаад гэвэл өөрснөө хөөрсөн түмэнд буруутгагдана, юу гэвэл, гэмт хэргийг зогсоох гэсэн нэгнийгээ эсрэг талын этгээд гэж дотооддоо яллаж эхэлнэ. Ингээд цааш нь С.Сигеле: “хөөрсөн түмний дунд муу муухай хүсэл шохоорхол аливаа сайн эхлэл санааг няц даран давдаг”, “хөөрсөн түмэн бол, ер нь, сайн юмнаасаа муу юманд илүү татагдсан байдаг”, “хөөрсөн түмэн бол муу муухайгийн нянг маш хурдан үржүүлж, сайн үйлсийн нянд амьдрах таатай нөхцөл олгохгүйгээр дарж устгадаг субстрат мөн” (62,63-р тал) гэх зэргээр дүгнэжээ.

Хөөрсөн түмэн үйлдэлд ордог механизмын талаар тэр үеийнхээ судлаач Пюльзе-ийн хэлснийг С.Сигеле их л зөвшөөрөн иш татжээ. Үүнд: “Хөөрсөн түмэн өдөгдөн сэрлээ; гэхдээ түүнийг, далайн давалгаа адилаар хөдөлгөөнд оруулж чадах хүч хараахан үйлчилж эхлээгүй байна; тогоо уурын даралтанд оржээ, гэвч уурыг гадагш нь гаргах ёстой хавхаг нээгдээгүй байна; бөөн дарийг бэлэн болгожээ, гэвч түүнийг ноцоон асаах галыг одоогоор хэн ч авчраагүй байна... За, одоо нэг хүн босоод ирэв, санаа гарч ирэв, эсхүл “тэр этгээдийг, ардын дайсныг цаазалъя” гэх юмуу, эсхүл “түүнийг, хөөрхий нөхрөө чөлөөлье” гэсэн уриалга дуулдлаа, ингэснээр түлхэц өгөгдөв, хавхаг онгойв, дарь авцалдав. Хөөрсөн түмэн гэдэг энэ дээ” хэмээн бичсэн ажээ (66-р тал).

С.Сигеле судалгаагаа ерөнхийд нь дүгнэж:

“Хэтэртлээ агзаганан бужигнаж, хилэгнэн эгдүүцсэн хөөрсөн түмэн зөвхөн тоо толгойн нөлөө байхад л богино хугацаанд жинхэнэ галзууралд ордог гэж эндээс дүгнэх нь аргагүй зөв байгаа биз дээ. Ийм байдалд орчихсоны дараагаар хөөрсөн түмэн хамгийн аймшигт хэрэг үйлдэхэд хүрдэг гэдэгт гайхаад байх юм ерөөсөө

алга. Тийнхүү, санаандгүйгээр нэг дор цугларсан 100, 1000, 2000 хүн хүч чадлаа ухамсарлаж, эндээ эзэн гэдгээ мэдэрсэн цагт өөрсдийгөө шүүгч болох, тэр ч бүү хэл алуурчин болох эрхтэй гэж үздэг нь бүрнээ зүйн хэрэг юм” хэмээн бичээд “Гэв гэнэт асар их хүч чадал орж, аллага таллагын төлөө шийтгэл хүлээхгүй гэдгээ ухаарах нь хүний толгойд дэндүү хатуудсан дарс юм, маш хурдан толгой эргэж, нүдний өмнүүр улаан цагирага эргэлдэж, хэтэрхий дэврэн хөөрцөглөснөөс хүн харгис хэрцгийг үйлдэхэд хүрдэг” гэсэн Тэн хэмээх судлаачийн үгийг иш татжээ (90-91-р тал).

Энэхүү хөөрсөн түмний сэтгэл зүйн гол шинж нь Би гэдэг этгээд энэ дотор орохлоороо өөрийн гэсэн гол сэтгэлээ алдаж бусдын түр зуурын авирт автдагт оршино.

Хүн өөрийн Би-ийг сэтгэлийн хувьд алддаг нь сониуч зангаасаа болоод даган дуурайхууд автагдах, ятгалгад орох хоёроосоо болдог байна. ХХ зуунд нэрд гарсан гарамгай сэтгэл зүйч, философич Эрих Фромм “Найдвараа хувьсгахуй” (УБ., 2007) гэдэг номондоо, “сониуч зан гэдэг нь идэвхигүй байхуйн илрэл юм” гээд, цааш нь “Сониуч зан бол элдэв янзын мэдээлэл, дуулиан шуугианаар амилж явдаг, тэгээд хэзээ ч үүгээрээ цадаж ханадаггүй, үүний учир нь сониуч зан бол гүн мэдлэгийг бус, үй түмэн дэмий мэдээллийг хөөж явдагт оршдог. Сониуч зан юуны өмнө хов яриагаар хоолоо хийдэг...” (87-р тал) гэсэн нь хөөрсөн түмэн үүсэх сэтгэл зүйн үндсийг судлан гаргахад чухал баримжаа болохоор байна. Энд Э.Фромм “сониуч зан гэдэг нь идэвхигүй байхуйн илрэл юм” гэж хэлсэн нь өөрийгөө хадгалж, сэтгэл хөөрлөө барихад идэвхигүй хандана гэсэн санаа юм.

Одоо, даган дуурайхуй, ятган нөлөөлөхүйн энгийн ерийн жишээг судлаачид хэрхэн тэмдэглэснийг дурдъя.

С.Сигеле «Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг» номондоо хүмүн Би дуурайхуйд автагдаж, ятгалгад ордгийн жишээг бусдаас иш

татах, өөрөө мэдээлэх зэргээр тод томруун харуулжээ.

Даган дуурайхуйд холбогдуулж тэр үеийн Францын Бордые гэдэг судлаачийн хэлсэн үгийг сонсоё. Тэрвээр: «Хүн бүхэн дууриах учиг учиртай, энэ учиг (чадвар) цугларан бөөгнөрсөн хүмүүсийн дунд дээд туйлдаа хүрдэг. Театрын танхимд, олон нийтийн хурал дээр хэн нэгэн нь алга бяцхан таших юмуу, ялимгүй шүгэлдэхэд л аль алиныг нь танхим тэр аяараа дагадаг нь үүний нотолгоо юм» гэжээ. (37-р тал) Дууриан дагах гэдэг бол зөн совингийн үр. Ухаандаа, аюул болоод хүмүүс тал тал тийшээ таран гүйлдэхэд, тодорхой хүн, аль түүрүүнд харагдсаныхаа хойноос даган гүйдэг нь ажиглагджээ.

Ийм үзэгдлийн талаар С.Сигеле бас өөрийн ажиглалтаа тэмдэглэжээ. Түүний бичсэнээс сийрүүлбэл, Та усны урсгал харах гэж гүүрний хөндлөвч түшин доошоогоо ширтээд зогсоод бай. Хэдхэн хоромын дотор таны дэргэд эхлээд цөөн хүн цугларна, тэгээд тэд таныг даган алмайран гөлрөх хоорондоо юуг ч үзэж хараагүй байж өөр дундаа: Тэр байна! Аль!....Яагаав тэр! Өө, одоо алга болчихлоо! гэгцгэнэ. Өдий төдий хүн үнэндээ байхгүй юмыг ингэж “харж, үзэж” эхэлдэг байна.

Ятган нөлөөлөхүйн нэг жишээг эртний Сири улсад дэлгэрсэн нэгэн үлгэрээс иш татаж харуулья.

Гэртээ суудаг нэгэн даяанч лам өргөлд барих гэж ишиг худалдаж авав. Үүнийг нь хулгайч нар алсаас хараад ишгийг салган авах арга сийлжээ. Лам ишгээ хөтлөөд гэрийнхээ гадаа ирэхэд хулгайч нар түүн рүү очоод, нэг нь: Та нохойгоор яах гэв? гэв. Хоёрдахь нь: Нохой хөтлөөд анд явах нь уу? гэв. Гуравдахь нь: Нохойгоо надад зарчихгүй юу гэв. Дөрөвдэх нь: нохойд хүрсэн хүн ариун угаал үйлдэх ёстой доо гэв. Лам, дөрвийн дөрвөн хүн ишгийг минь нохой гээд байна. Захын худалдаачин намайг ховсдож нохойгоо ишиг гээд зарсан бололтой хэмээн бодож ишгээ орхин ариун угаал үйлдэхээр гүйж одов. Зальгчууд ч

ишгийг хөтлөн арилав.

Ийм мэтийн даган дуурайхуй, түүнээс гарсан ятган нөлөөлөхүй хөөрсөн түмний дундахь хувь Би-д нөлөөлж юу л бол юуг хийлгэдэг байна. Урлаг, спортын тоглолтыг сонирхож, түүндээ автаж хөгжөөн дэмжих үедээ ч хүн өөрийн Би-гээ алддаг ажгуу.

Дорнын гүн ухааны үүднээс үзвэл хувь Би гэдэг шүтэн барилдсаны дүн учраас ийм явдал тохиолддог байна. Хувь Би гэдэг бол бие даасан, ганцаараа, бусдаас салангид, хөдөлшгүй зүйл биш болой.

Хөөрсөн түмэн галзууран гэмт хэрэг үйлдсэн үед хууль яах ёстой вэ? Хэнийг нь шийтгэх вэ? Энэ нь их нарийн түвэгтэй асуудал ажээ. Хэрхэхийг хууль шүүх мэдэх ёстой. Мэдэхийн тулд хуулийн заалтууд хэрэгтэй биз. Энгийн ухаанд ойлгомжтой зүйл гэвэл, гэмт хэргийг биечлэн үйлдсэн этгээд, хөөрсөн түмнийг зохион байгуулсан этгээд хоёр л лав нийгмийн өмнө, ингэхлээр хуулийн өмнө хариуцлага хүлээх ёстой бизээ.

Ийм юманд хуулийн заалт, зүйл анги хэрэгтэй. Хөөрсөн түмэн зөв залагдахгүй бол заавал ноцтой асуудалд хүргэнэ. Хөөрсөн түмнийг өдөөж үүсгэхгүй байхад нийгэм, төр засаг, ард иргэд бүх талаас нь анхаарууштай болж буйг өнөөгийн цаг үе харуулж байгаа бус уу!

Ер нь, хуулиар хориглоогүй бүхнийг хийж болно гэсэн ёс суртахууны гажуудалтай үзэл бодол манайд далдуур газар авч байгааг бид хаа хаанаа харгалзан бодох ёстой билээ.

“Хилэн нь бадарч даварсан хөөрсөн түмний үйлдсэн гэмт хэргийн буруутан нь бүрэн хариуцлага хүлээх үү, хагас хариуцлага хүлээх үү гэж ярьж суух хэрэг бидэнд алга; энэ бол мунхаг санаа илэрхийлсэн хуучин томъёолол мөн; бид хөөрсөн түмэнд сөрөн зогсох ухаалаг аргыг л олох ёстой. Бидний зайлшгүй шийдвэрлэвэл зохих зарчим энэ л байна” гэсэн С.Сигелийн ончтой үгээр энэ бяцхан өгүүллээ жаргаасугай.